

## МОНГОЛ-ХЯТАДЫН ХУДАЛДАА, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА, ЧИГ ХАНДЛАГА

Ма.Бүрэнжаргал\* Сун Рүй Жи\*\*

**Товч агуулга:** Монгол улс нь БНХАУ-ын чухал хөрш улс бөгөөд хоёр улс нь эдийн засаг, худалдааны салбарт харилцан ашигтай хамтын ажиллагааг хэрэгжүүлсээр ирсэн. Өдгөө хоёр улсын хооронд иж бүрэн стратеги түншлэлийн харилцааг бий болгож, БНХАУ нь Монгол улсын гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын хамгийн том түншлэгч хэвээр байна. Уг судалгааны ажил нь Монгол-Хятадын гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааны хөгжлийн чиг хандлагад эмпирик болон онолын шинжилгээ хийж, хоёр талын хамтын ажиллагааны урт хугацааны стратегийн ашиг сонирхолын үүднээс улс төрийн харилцан итгэлцлийг бэхжүүлэх, олон нийтийн үзэл санааны үндэс суурийг батжуулах, эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааг өргөжүүлэх зэрэг асуудалд санал дэвшүүлнэ.

**Түлхүүр үгс:** Монгол-Хятадын харилцаа, Монгол-Хятадын худалдаа, хөрөнгө оруулалтын интеграцийн чиг хандлага, урт хугацааны стратегийн ашиг сонирхол

### Сэдвийн үндэслэл

Монгол улс нь Хятад улсын хойд хэсэгтэй өргөн уудам нутгаар хиллэдэг, хилийн зурвасын уртын хэмжээгээр хамгийн ихэд тооцогдох хөрш улс юм. Монгол-Хятад хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосоноос хойшхи 60 жилийн хугацаанд цөөнгүй асуудлууд үүсч байсан ч сайн хөршийн найрсаг харилцаагаа хадгалсаар ирсэн. Хэдийгээр хоёр улсын эдийн засгийн хамтын ажиллагаа нь зарим нэг таагүй хүчин зүйлсийн нөлөөнд өртсөн ч хамтын ажиллагааны давуу талууд нь эдгээр сорилтуудыг даван туулах хүч болж өгчээ. Монгол-Хятадын худалдаа хөрөнгө оруулалтын интеграцчилал гэдэг нь үндэстэн дамнасан компани эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны хүрээнд зөвхөн түүхий эд, хагас боловсруулсан болон бэлэн бүтээгдэхүүнийг хил дамжуулан тээвэрлэх, транзит арилжаа хийхээр хязгаарлагдах бус хүлээн

\* Өвөрмонголын их сургууль, Монгол судлалын сургууль, (Email) burnee88@imu.edu.cn

\*\* Өвөрмонголын их сургууль, Эдийн засгийн сургууль, (Email) nmhxx2006@163.com

авагч орны үйлдвэрлэлд хөрөнгө оруулалт хийж Үйлдвэрлэл-Борлуулалт-Орлого гэсэн циклийг бий болгох, хүлээн авагч орон биет болон биет бус хөрөнгийг тасралтгүйгээр нэмэгдүүлэх, үүний үр дүнд олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын харилцан нэгдэл, түүний урт хугацааны тогтвортой байдлыг хангахыг тусгасан ойлголт юм.

Хөгжлийн энэхүү замаар Монгол-Хятад хоёр улсын худалдаанд бий болох саадыг арилгах, худалдаа хөрөнгө оруулалтыг хялбарчлах, дотоод эдийн засгийн бүтцэд өөрчлөлт оруулах, аж үйлдвэрлэлийг өргөжүүлэх, улс төрийн харилцан итгэлцлийг сайжруулах, уламжлалт сайн хөршийн найрсаг харилцааг хадгалах, Хятадын өөрчлөлт шинэчлэлийг гүнзгийрүүлэх зэрэг стратегийн өндөр ач холбогдолтой юм.

### **Судлагдсан байдал**

Монгол улс газар зүйн байршлын хувьд БНХАУ болон ОХУ-ны улсын дунд оршдог. Монгол-Хятадын худалдаа хөрөнгө оруулалтын хөгжлийн асуудал нь “Нэг бүс-Нэг зам” стратегийн “Тал нутгийн зам” дорнод бүсийн эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаанд чухал байр суурь эзэлж, сүүлийн жилүүдэд Хятад судлаачдын анхаарлыг ихээр татаж байна.

### **Монгол-Хятадын худалдааны талаар**

Монгол-Хятад хоёр улсын худалдаа нь ихэвчлэн аж ахуй нэгжүүдийн хоорондын шууд харилцааны хэлбэрээр, хөрөнгө оруулалт-худалдаа хосолсон хэлбэрээр, хил дамнасан худалдааны хэлбэрээр, хил дамнасан бага хэмжээний худалдааны хэлбэрээр, хилийн бүс нутгийн эдийн засаг, техникийн хамтын ажиллагаа болон худалдааны чөлөөт бүсийн хэлбэрээр явагдаж байна<sup>3</sup>. Сүүлийн жилүүдэд хөрөнгө оруулалт-худалдааны хосолсон хэлбэр нь хоёр улсын аж ахуй нэгжүүдийн сонирхолыг ихээр татаж байна. Энэ нь ихэвчлэн ашигт малтмал, байгалийн нөөцийн салбарт ажиглагдаж байгаа бөгөөд цаашдаа хоёр улсын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны хөгжих бололцоо хамгийн ихтэй салбарт тооцогдож байна. Хятад улс дахь Монгол-Хятадын эдийн засгийн хамтын ажиллагаатай холбогдолтой судалгаанууд нь ихэвчлэн хоёр талын худалдааны асуудлуудад чиглэгдсэн бөгөөд гадаадад судлагдсан нь маш цөөн байна. Нэгдүгээрт, нөөцийн давуу байдал болон бүтцийн тохиромжтой байдлын үүднээс хоёр талын худалдааны хөгжлийнхандлагад судалгаа хийгджээ. Өнгөрсөн зууны 90-ээд оны үед хоёр улсын худалдаа

<sup>3</sup> Оронч/敖仁其. Монгол болон Өвөр Монголын эдийн засгийн хамтын ажиллагааны өнөөгийн байдал, хэтийн төлөв/内蒙古与蒙古国经贸合作现状与前景[J]. Зүүн хойд Азийн форум/东北亚论坛, 2000 (10) : 35-38.

нь үндсэндээ Хятад улс бэлэн бүтээгдэхүүнээ Монголын ашигт малтмал, боловсруулаагүй арьс, ноос, ноолуур, төмөрлөг зэрэг түүхий эд материалаар арилжих хэлбэрээр явагдаж байсан. Хоёр улсын худалдаа нь ихээхэн харилцан нөхвөрлөх шинжтэй байсан<sup>4</sup>. Монгол улс хүн ам цөөтэй, байгалийн баялагийн арвин их нөөцтэй хэдий ч зах зээлийн багтаамж харьцангуй бага, хөрөнгө санхүүгийн болон техникийн хангамж нөхцөлөөр тааруу. Харин Хятад улс зах зээлийн багтаамж их, хүчирхэг санхүүгийн чадамжтай, дэвшилтэт техник тоног төхөөрөмжтэй, ажиллах хүчний арвин их нөөцтэй<sup>5</sup>.

Хоёр улсын эдгээр хоорондоо ялгаатай харьцангуй давуу талууд нь худалдааны харилцан нөхвөрлөх чанарыг нэмэгдүүлж байна<sup>6</sup>. Газар нутгаараа шууд хиллэн оршдог, өөр өөрийн давуу талуудтай зэргээс ашиг сонирхолоо харилцан нөхвөрлөх боломжтой<sup>7</sup>. Хоёрдугаарт, бүс нутгийн хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх үүднээс хоёр улсын худалдааны хөгжлийн тухайд судалгаа хийгдсэн байна<sup>8</sup>. Монгол улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнээс хойш гадаад худалдааны олон талт бүтэц бий болж дан ганц Зөвлөлт холбоот улсаас хамааралтай байсан гадаад худалдаа дэлхийн таван тивийн улсуудтай нээлттэй хамтын ажиллагааг хөгжүүлж, худалдааны түншүүдийн тоо аажмаар нэмэгдэж ирсэн. Монгол-Хятад хоёр улс нь газар нутгаараа хиллэн оршдог учир газар зүйн байршил нь хамтын ажиллагааны том давуу тал болох нь дамжиггүй юм. Эдийн засгийн хамтын ажиллагааны бодит болон боломжит байдлаас харвал, хоёр улс эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны хэлбэр, арга замаа тасралтгүй өөрчилж шинэчлэн, бүс нутгийн дотоод хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааг өргөжүүлж байна<sup>9</sup>. Улс төр, соёл, эдийн засаг худалдааны хамтын ажиллагааны таатай харилцааг дагаад Монгол-Хятад хоёр тал газар зүйн байршлын том давуу талаа уламхээр ашиглах хэрэгтэй. Бүс

4 Оронч /敖仁其. Монгол болон Өвөр Монголын эдийн засгийн хамтын ажиллагааны өнөөгийн байдал, хэтийн төлөв/内蒙古与蒙古国经贸合作现状与前景[J]. Зүүн хойд Азийн форум /东北亚论坛, 2000 (10): 35-38.

5 Li Jun Jiang/李俊江, Song Bo/宋博. Монгол-Хятад хоёр улсын эдийн засгийн хамтын ажиллагааны өнөөгийн байдал болон хөгжлийн төлөв/中蒙经贸合作的现状与发展前景[J]. Зүүн хойд Азийн форум /东北亚论坛, 2008 (3): 25-28.

6 Yao Hai Hua/姚海华. Монгол-Хятад хоёр талын худалдааны бүтцийн шинэчлэлийн шинжилгээ/中国与蒙古国双边贸易结构演进分析[J]. Өвөр монголын нийгмийн шинжлэх ухааны сэтгүүл /内蒙古社会科学(汉文版), 2009 (6): 1-6.

7 Zhang XiuJie /张秀杰. Зүүн хойд Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаан дахь Монгол, Орос, Хятадын эдийн засгийн корридорын судалгаа/东北亚区域经济合作下的中蒙俄经济走廊建设研究[J]. Эдийн засгийн өсөлт, хөгжил/经济增长与经济发展, 2015 (6): 6-10.

8 Энхээ/恩和. Зүүн хойд Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа, Өвөр Монголын эдийн засгийн хөгжил: Одоогийн байдал болон хэтийн төлөв/东北亚区域经济合作与内蒙古经济发展:现状与前景[J]. Зүүн хойд Азийн форум/东北亚论坛, 1998 (4): 51-55.

9 Li Hui/李慧. Монгол-Хятадын эдийн засаг худалдааны хамтын ажиллагааны өнөөгийн байдал болон бодлого/中蒙经贸合作现状及对策[J]. Олон улсын эдийн засаг худалдаа/国际经贸, 2008(1): 11-13.

нутгийн эдийн засгийн интеграцчилалын нөхцөлд хоёр улс хоорондын харилцаа холбоо болон олон талт худалдааг идэвхитэй өргөжүүлж, эрдэс баялаг, эрчим хүчний салбарыг хөгжүүлэх талаар хамтран ажиллах нь хоёр улсын харилцааны хөгжлийг түргэтгэнэ<sup>10</sup>. Монгол, Орос, Хятад гурван улсын эдийн засгийн корридор нь дэд бүтцийн салбарын харилцааг бий болгож, зүүн хойд азийн хотын бүлэгжилтийг сайжруулж, бүс нутгийн эдийн засгийн интеграцчилалын хөгжилд түлхэц өгч байна<sup>11</sup>. Түүнчлэн зарим судлаачид Монгол-Хятадын худалдааны хамтын ажиллагаанд оршиж буй сул талуудад шинжилгээ хийж, экспортын бүтцийг оновчтой болгох, хоёр орныг холбосон хилийн төмөр замын салбарын хүчин чадлыг нэмэгдүүлэх шаардлагатай гэсэн санал боловсруулжээ<sup>12</sup>. Худалдаанд оролцож буй Хятадын аж ахуй нэгжүүдийн дийлэнх нь жижиг, дунд аж ахуй нэгжүүд учир Монгол улсад үзүүлэх нөлөөлөл бага байна<sup>13</sup>. Монгол-Хятадын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаанд худалдааны горим зөвхөн нэг загварт баригдаж явагдах, Америк, Япон улсууд Монгол улсын эдийн засгийн ашиг сонирхолд нөлөөлөх зэрэг асуудлууд оршсоор байна<sup>14</sup>. Монгол-Хятад хоёр улсын худалдааны горим нь харьцангуй давуу тал бүхий байгалийн нөөцөд тулгуурласан бүтээгдэхүүнийг экспортлодог. Энэ нь аж үйлдвэрлэлийн хөгжлийн хоцрогдолтой түвшинг илтгэн харуулж байгаа бөгөөд урт хугацаанд авч үзвэл “Харьцангуй ашгийн занга”-д амархан өртөнө<sup>15</sup>. Хоёр улсын аль алинд эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны хязгаарлагч хүчин зүйлс байсан хэвээр байна.

Тухайлбал, Монгол улсын зах зээлийн төлөв байдал оновчтой бус, дэд бүтцийн салбарын хөгжил сул, ажиллах хүчний хангамж дутагдалтай, Хятад улсын хувийн аж ахуй нэгжүүд Монгол улсын зах зээл, хууль эрх зүй, байгаль орчны бодлогыг баримталдаггүй зэрэг асуудлууд голлон оршсоор байна<sup>16</sup>.

10 Zhang Xiujie/张秀杰. Зүүн хойд Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаан дахь Монгол, Орос, Хятадын эдийн засгийн корридорын судалгаа/东北亚区域经济合作下的中蒙俄经济走廊建设研究[J]. Сурах, эрэлхийлэх/学习与探索, 2015(10): 105-108.

11 Hu Jian/胡健. “Нэг бүс-Нэг зам” стратегийн бодлого, түүний хэрэгжилтийн судалгаа/“一带一路”战略构想及其实践研究[M]. Бээжин. Цаг үе хэвлэлийн үйлдвэр/北京. 时事出版社, 2016: 1-1.

12 Pu Yang Chun/朴养春. Монгол-Хятадын худалдааны хамтын ажиллагааны хэтийн төлөвлөлт/中蒙贸易关系的展望[J]. Yanbian Их сургуулийн ЭШ-ий сэтгүүл/延边大学学报, 1997(4): 1-4.

13 Энхээ/恩和. Зууны эргэлтэнд байгаа Монгол-Хятадын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаа: Одоо болон ирээдүйд/世纪之交的中蒙经贸关系: 现状与展望[J]. Өвөр Монголын их сургуулийн ЭШ-ий сэтгүүл/内蒙古大学学报, 1999 (6): 39-46.

14 Tang Hui Liang/唐辉亮. Монгол-Хятадын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны хөгжил, түүнд оршиж буй асуудал/中蒙经贸关系的发展与存在的问题[J]. Бизнес Таймс/商业时代, 2006(34): 36-37.

15 Бүрэнжаргал/布仁吉日嘎拉. Юаны ханшны өсөлт Монгол улсын эдийн засагт нөлөөлөх нөлөөллийн судалгаа/人民币升值对蒙古国经济发展的影响研究[J]. Өвөр Монголын санхүү эдийн засгийн сургуулийн ЭШ-ий сэтгүүл/内蒙古财经学院学报, 2007(4): 20-25.

16 Shao Bing/邵冰. Монгол-Хятадын эдийн засаг, хамтын ажиллагааны өнөөгийн байдал, бодлого/中

Хэдийгээр ОХУ, БНХАУ нь Монгол улсын хоёр их хөрш гүрэн боловч түүхийн замнал, геополитикийн харилцаанаас шалтгаалан Монгол улс хөрш улсуудаасаа харилцан адилгүйгээр сэрэмжилж, АНУ, Япон зэрэг хөгжингүй орнуудтай найрсаг харилцаагаа хадгалж, тэрүүгээр зогсохгүй АНУ-ыг өөрийн гурав дахь хөрш улс хэмээн үзэж байна<sup>17</sup>.

### **Монгол-Хятадын хөрөнгө оруулалтын талаар**

Олон улсын хөрөнгө оруулалтыг ерөнхийд нь шууд болон шууд бус хөрөнгө оруулалт гэж ангилна. Хоёр улсын хоорондох шууд бус хөрөнгө оруулалтын эзлэх хувь харьцангуй бага тул уг судалгааны ажилд хоёр улсын хоорондох хөрөнгө оруулалт гэдэгт шууд хөрөнгө оруулалтыг авч үзэв. Бүс нутгийн эдийн засгийн интеграцчилалыг дагаад ГШХО нь зөвхөн мөнгөн капиталын хил дамнах урсгал бус биет капитал, технологи, менежмент, санхүү зэрэг хөрөнгийн олон хэлбэрийг нэгтгэсэн хөрөнгө оруулалт болж байна<sup>18</sup>. Хятад улсын хэмжээнд Монгол-Хятад хоёр улсын хөрөнгө оруулалтын талаархи судалгаа харьцангуй олон.

Нэгдүгээрт, Монгол улс дахь Хятадын бичил хөрөнгө оруулалтын талаар судалжээ. Монгол дахь Хятадын юаны хөрөнгө оруулалт нь голлон мал аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалт хийхэд чиглэгдэж байсан бол 2005 оноос уул уурхайн эрэл хайгуул, зам харилцааны судалгаанд чиглэгдэх болсон<sup>19</sup>. 2008 оны олон улсын санхүүгийн хямралын дараагаар Монгол дахь Хятадын хөрөнгө оруулалт боловсруулах болон аж үйлдвэрийн парк байгуулах зэрэгт чиглэж эхэлсэн<sup>20</sup>. Түүний дотор Монгол дахь Хятадын нийт хөрөнгө оруулалтын 65-аас дээш хувь нь уул уурхайн салбарт хийгджээ<sup>21</sup>.

Хоёрдугаарт, Монгол-Хятад хоёр улсын хөрөнгө оруулалтын хамтын ажиллагаанд оршиж буй асуудлуудыг судалжээ. Монголын байгалийн баялагийн салбарт оруулсан гадаадын компаниудын хөрөнгө оруулалт Монголын эдийн

---

蒙经贸合作的现状及对策[J]/经济视角, 2011(8):168-169.

17 Na Lin/娜琳. Монгол улсын “Олон талт” гадаад хамтын ажиллагааны бодлого, их гүрнүүд дэхь харилцаа /蒙古国“多支点”外交战略与大国关系[J]/2004(1):82-87.

18 Олон улсын шууд болон шууд бус хөрөнгө оруулалтын нягтралын шинжилгээ/浅析国际直接投资和间接投资的融合, 会计城, <http://www.kjcity.com/news>, 2015-11-10.

19 Shang Pei Feng/尚佩峰、Zhang Jun/张军. Мандуул боомтын гаднах хил дамнасан хөрөнгө оруулалт, санхүүгийн үйлчилгээний нөхцөл байдлын судалгаа/对满都拉口岸境外跨境投资和金融服务情况的调查[J]. Санхүүгийн нягтлан бодох бүрдгэл/金融会计, 2009 (6) : 19-20.

20 Jin Feng Hua/金凤花、Yu Li Min/于丽敏.Heilongjiang мужийн гадаад дахь хөрөнгө оруулалтын өнөөгийн байдал, хөгжлийн бодлого-Монгол, Оросын жишээн дээр /黑龙江省对外投资现状与发展对策——以俄、蒙两国为例[J]/黑龙江对外经贸, 2011 (8) : 14-16.

21 Jiang Tao/姜涛. Монгол дахь Хятадын шууд хөрөнгө оруулалтын худалдааны үр нөлөөний судалгаа/中国对蒙古直接投资的贸易效应研究[D], Hebei муж: Anhui Их сургууль/合肥: 安徽大学, 2015: 5-1.

засгийн өсөлтөд түлхэц болсон<sup>22</sup>. Монгол улсын хувьд дэд бүтцийн салбарын хөгжил сул, мэдээлэл хаалттай, хууль эрх зүйн тогтолцоо тийм ч боловсронгуй бус, банкны систем хөгжингүй бус зэрэг нь ГШХО-ын хязгаарлагч гол хүчин зүйлсхэвээр байна<sup>23</sup>. Монгол дахь Хятадын шууд хөрөнгө оруулалтын дийлэнхи нь уул уурхайн салбарт төвлөрсөн учир салбарын болон Монгол улсын засгийн газрын бодлогын нөлөөнд ихээр өртөж байна<sup>24</sup>. Хятадын хөрөнгө оруулагч компаниуд олон улсын хамтын ажиллагааны туршлага, чадвар сул байгаагаас болж Монгол орны байгаль орчинг ихээр сүйтгэж байна<sup>25</sup>.

Монгол дахь Хятадын шууд хөрөнгө оруулалтнэг талыг барьсанбайгаа ньхөрөнгө оруулалтын эрсдэлийг нэмэгдүүлж байна. Түүнчлэн хувийн хөрөнгө оруулалтын төсөл давамгайлсан хөрөнгө оруулалтын бүтэц нь албан ёсны хөрөнгө оруулалтын горимоор явагдахгүй, татвараас зайлсхийх зэрэг хууль бус үйлдлүүд байнга үүсч байгаа нь Монголын тал тус хамтын ажиллагаанд итгэх итгэлийг ихээр бууруулж байна<sup>26</sup>. Иймд Хятадын тал хөрөнгө оруулалтын бүтцээ сайжруулах, томоохон аж ахуй нэгжүүдийг Монголд хөрөнгө оруулалт хийхийг дэмжих, ажиллах хүчний чадварыг сайжруулах, Монголын тал баримтлах бодлогын тогтвортой байдлыг хангах, хууль тогтоомжийг төгөлдөржүүлэх, дэд бүтцийн салбарын хөрөнгө оруулалтын удирдамжийг өргөтгөх хэрэгтэй<sup>27</sup>. “Ойртох зарчим”-ын онолын үүднээс Монгол-Хятад хоёр улсын хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд тэргүүлэх ач холбогдол өгөх хэрэгтэй<sup>28</sup>.

22 BatbilegZayajargal.Bilateral Relations between China and Mongolia[D].Shan Dong University, 2014-4-11.

23 Shang Pei Feng/尚佩峰、Zhang Jun/张军. Мандуул боомтын гаднах хил дамнасан хөрөнгө оруулалт, санхүүгийн үйлчилгээний нөхцөл байдлын судалгаа/对满都拉口岸境外跨境投资和金融服务情况的调查[J]. Санхүүгийн нягтлан бодох бүрдгэл/金融会计, 2009 (6) : 19-20.

24 Lin Yan/林燕.Өвөр Монголын ААН-үүдийн Монгол, Орос дахь хөрөнгө оруулалтын асуудлын судалгаа/内蒙古企业对俄蒙投资问题研究[J]. Өвөр Монголын санхүүгийн судалгаа/内蒙古金融研究,2015(3):33-34.

25 Zhang Ye Fang/张野芳. Монгол-Хятадын харилцааны хөгжлийн хязгаарлагч хүчин зүйлс/中蒙关系发展中的阻碍因素[D].Jilin муж: Jilin-ий Их сургууль/吉林: 吉林大学, 2009:4-1.

26 Bai Qing Sen/白庆森、Kang Xiao Guo/康晓国. Монгол-Хятадын худалдаа, хөрөнгө оруулалтын өнөөгийн байдал, ирээдүйн хүлээлт—БНХАУ-ын эдийн засгийн хөгжлийн горимыг өөрчлөх үндсэнд/中蒙两国贸易投资现状及未来展望——基于中国经济发展方式转型的视角[J]. Бизнесийн эдийн засаг/商业经济, 2011 (23) : 79-81.

27 Fang Fang/芳芳.Монгол дахь Хятадын шууд хөрөнгө оруулалтын өнөөгийн байдлын судалгаа/中国对蒙古国直接投资现状研究[D] Хөххот: Өвөр Монголын их сургууль/呼和浩特: 内蒙古大学, 2010-6-1.

28 Li Xue Xin/李雪欣. Гадаад дахь Хятадын шууд хөрөнгө оруулалтын аж үйлдвэрийн сонголтын хэвлэлцүүлэг/论中国对外直接投资的产业选择[J].Shenyang Их сургууль ЭШ-ний сэтгүүл /沈阳大学学报, 2000 (1) : 27-30.

### **Монгол-Хятадын худалдаа, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааны хөгжлийн талаар**

БНХАУ-ын дотоодын зарим судалгаанууд нь олон улсын улс төр, эдийн засаг<sup>29</sup>, нийгэм, байгаль орчны нөхцөлийн талаас Монгол-Хятадын эдийн засгийн хамтын ажиллагааны харилцааг хөгжүүлэх стратегизорилго<sup>30</sup> болон судалгааны аргуудыг<sup>31</sup> харьцангуй системчилсэн байдлаар судалж, дүгнэлт хийжээ. Эдгээр судалгаа нь бидэнд холбогдох асуудлыг үргэлжлүүлэн нарийвчлан судлах үндэс суурь болох болно. Монгол-Хятадын худалдаа эсвэл хөрөнгө оруулалтын хөгжлийн асуудлаар судалсан гадаад, дотоодын судалгаанууд нь ихэвчлэн Монгол-Хятадын худалдаа, хөрөнгө оруулалтын харилцааны онцлог, оршиж буй асуудлууд болон нийгэм, хууль, байгаль орчны хүчин зүйлс түүнд хэрхэн нөлөөлж байгаа талаар судалжээ. Гэвч эдгээр судалгаанууд нь Монгол-Хятадын худалдаа хөрөнгө оруулалтын интеграцчилалын хөгжлийн чиг хандлагын асуудалд төдийлөн анхаарал хандуулж чадаагүй байна.

### **Монгол-Хятадын худалдаа, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааны чиг хандлагад хийсэн эмпирик судалгаа**

Одоогийн Монгол-Хятадын худалдаа, хөрөнгө оруулалтын хоорондын харилцан хамаарал болон хөгжлийн түвшинг тодорхойлохын тулд орчин үеийн олон улсын эдийн засаг судлал дахь олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын хоорондын харилцан нөхөх болон орлох шинжийн онолд тулгуурлав. Монгол-Хятадын худалдаа, хөрөнгө оруулалт хөгжлийнхөө явцад харилцан хамтрах шинжтэй эсвэл интеграцчилалын хөгжлийн хандлагатай байна гэсэн таамаглал дэвшүүлсэн.

### **Загварын тавил**

Вектор авторегрессийн загвар (vector auto-regression model) нь multifunction simultaneous form хэлбэртэй учир хугацааны цувааны хувьсагчид хоорондын динамик нөлөөлөлд торхиромжтой. Уг судалгааны ажилд Монгол-Хятад хоёр улсын хоорондын экспорт, импортын хэмжээ болон хөрөнгө оруулалтын хоорондын хамаарлыг судалсан. Динамик регресс (dynamic regression)-д тохиромжтой вектор авторегрессийн загвар дараах байдалтай байна.

29 Gao Ben Quan/高本权: Зүүн хойд Азийн олон улсын тавцан дахь Монгол-Хятадын хамтын ажиллагааны харилцааны хэлэлцүүлэг》/试论东北亚国际背景下的中蒙合作关系[J], Өвөр Монголын санхүү эдийн засгийн их сургууль /内蒙古财经学院学报,2009(6):39-42.

30 Gao Ben Quan/高本权: Тэнцвэр—Монгол-Хятадын эдийн засгийн хамтын ажиллагааны бодлого, зорилго/均衡——中蒙经济合作关系中的策略与目标[J], Өвөр Монголын санхүү эдийн засгийн их сургууль /内蒙古财经学院学报,2008(6):51-54.

31 Gao Ben Quan/高本权: Монгол-Хятадын хамтын ажиллагаан дахь эргэцүүлэл /中蒙合作关系研究中的几点思考[J],Өвөр Монголын санхүү эдийн засгийн их сургууль /内蒙古财经学院学报,2010(6):50-52.



$$Y_t = C + \sum_{i=1}^k AY_{t-i} + \epsilon_t$$

Үүнд:

$Y_t$ -IM, EX, TEI, FDI – аас бүрдсэн баганан вектор (column vector)

A- коэффициент матриц (coefficient matrix)

C -огтлолцох хугацаа (intercept term)

$\epsilon_t$  - санамсаргүй алдааны матриц (random error matrix)

t - хугацаа

i - хугацааны хоцрогдол (lag phase)

### **Түүврийн сонголт**

Монгол-Хятадын худалдаа, хөрөнгө оруулалтын хөгжлийн онцлогийг судлах зорилгоор жил бүрийн Монгол-Хятад хоёр улс хоорондын экспорт, импорт, экспорт импортын нийт хэмжээ болон Монгол дахь Хятадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ гэсэн 4 объектийг эмпирик судалгааны хувьсагчаар сонгож авч тус бүрийг EX, IM, TEI, FDI гэж тэмдэглэв. Хувьсагч бүрээс натураль логарифм (natural logarithm) авсны дараагаар хувьсагч хоорондын хамаарал өөрчлөгдөхгүй учир цуваа бүрд натураль логарифм авч хувьсагчдыг LNEX, LNUM, LNTEI, LNFDI гэж өөрчлөн тэмдэглэв.


### **Тоон мэдээллийн эх сурвалж**

Уг судалгааны ажилд Монгол-Хятад хоёр улс хоорондын экспорт, импорт, экспорт импортын нийт хэмжээ, Монгол дахь Хятадын шууд хөрөнгө оруулалтын тоо материалыг ашигласан бөгөөд холбогдох тоон мэдээллийг 2006-2015 оны “Хятадын гадаад худалдаа, эдийн засгийн статистикийн эмхэтгэл”- ээс авч ашиглав. 1995-2005 онуудын тоон мэдээллийг “Хятадын бизнесийн статистикийн эмхэтгэл”, “Хятадын гадаадын хөрөнгө оруулалтын статистикийн мэдэгдэл” болон Өвөр Монголын хөгжил, шинэчлэлийн хорооны анхдагч мэдээллээс авсан. Андагч болон статистикийн тоон мэдээллийг шууд авч ашигласан бөгөөд зарим хуримтлагдсан тоон өгөгдөлд салган тооцоолол хийсэн. Үүнд, экспортын хэмжээ, импортын хэмжээ, экспорт импортын нийт хэмжээ, шууд хөрөнгө оруулалтын хэмжээг арван мянган доллараар илэрхийлж, аравтын орны нарийвчлалтайгаар авч, таслалын ард 5-аас дээш байвал зэрэг дэвшүүлэн тавьсан.



### Эмпирик тест

**Тогтворжилтын тест (stationary test) :** Нэгдүгээрт, ажиглалтын хувьсагчдын хандлагын зургаас бидний сонгон авсан 4 хувьсагч бүгд intercept term, trend term –тэй байгааг харж болно. (Зураг 1)



**Figure 1** The trend line of variables LNEEX, LNFDI, LNIM, LNTEI

Хоёрдугаарт, эмпирик судалгаа хийхээс өмнө ADF тестээр хугацааны цувааны(time series) утгуудад stationary test хийсэн. ADF нь гурван туршилтийн тэгшитгэлтэй<sup>32</sup>.

$$Y_t = \gamma Y_{t-1} + \sum_{j=1}^p \lambda_j \Delta Y_{t-1} + \vartheta_t$$

$$Y_t = \alpha_0 + \gamma Y_{t-1} + \sum_{j=1}^p \lambda_j \Delta Y_{t-1} + \vartheta_t$$

<sup>32</sup> Анхаарах: Хамгийн эхний тэгшитгэлийн дараагийн хоёр тэгшитгэлээс intercept term, trend term-ийг агуулсан эсэхээрээ ялгагдана.

$$Y_t = \alpha_0 + \alpha_{1t} + \gamma Y_{t-1} + \sum_{j=1}^p \lambda_j \Delta Y_{t-1} + \vartheta_t$$

ADF тестийн үр дүнгээр (Хүснэгт1) бүх хувьсагчийн туршилтын утга харгалзах критик утга (critical value)-аас бага байна. Иймд хувьсагчид unit root-тэй гэсэн анхны таамаглалаас татгалзаж байна. Энэ нь бүх хувьсагч 5%-ийн ач холбогдлын түвшин (significance level of 5%)-д тогтвортой хувьсагч (stationary variables) болно. Иймд LNIM , LNEX, LNTEI, LNFDI нь бүгд I(2)-ийн single integer sequence болно.

Table 1 ADF Unit Root Results of variables

ADF test						
variable	ADF test value	1% critical value	5% critical value	10% critical value	P value	Whether smooth
LNIM	-4.120583	-4.571559	-3.690814	-3.286909	0.0230	yes
LNEX	-5.150269	-4.728363	-3.759734	-3.324976	0.0050	yes
LNTEI	-4.536139	-4.728363	-3.759743	-3.324976	0.0138	yes
LNFDI	-4.398755	-4.728363	-3.759743	-3.324976	0.0173	yes


**Co-integration regression test:** co-integration regression test- ийг хийхээс өмнө параметруудийн үнэлгээ хэтэрхий ихээс үүдэн загварын чөлөөт байдал алдагдахаас зайлсхийж хугацааны хоцрогдлын оновчтой түвшин (optimal lag order number)-г тодорхойлсон. VAR загварт хугацааны хоцрогдол их байх тусам тайлбарлагдах мэдээлэл илүү өргөн цар хүрээтэй байна. VAR загварын хугацааны хоцрогдлын оновчтой түвшин (optimal lag order number)-г хүснэгт 2-г харуулбал:

Table 2 VAR model's Lag Length Criteria Inspection

Lag	LogL	LR	FPE	AIC	SC	HQ
0	28.31783	NA	7.89e-07	-2.701981	-2.504121	-2.674699
1	72.74828	64.17731*	3.55e-08*	-5.860920	-4.87161*	-5.72450*
2	89.61314	16.86486	4.51e-08	-5.95701*	-4.176272	-5.711475

Дээрх хүснэгтээс LR, FPE, SC, HQ үзүүлэлтүүд нь 5%-ийн ач холбогдлын түвшин (significance level of 5%)-д Lag 1 үед VAR загвар харьцангуй оновчтой, үзүүлэлт AIC нь 5%-ийн ач холбогдлын түвшин (significance level of 5%)-д Lag 2 үед VAR загвар харьцангуй оновчтой байгааг харж болно. Оновчтой

хоцрогдлын бүтэцн сонголт нь AIC (Akaike Information Criterion) болон SC (Schwarz Criterion)-д дулгуурлан тодорхойлогддог. Загвараар хувьсагч хоорондын динамик хамаарлыг илүү бодитойгоор илэрхийлэх, чөлөөт байдлыг алдагдуулахгүйн тулд Lag 2 үеийн VAR загварын хугацааны хоцрогдлын оновчтой түвшин (optimal lag order number)-г сонгон авсан. Загварын тогтвортой байдлыг харуулахын тулд VAR загварт (2) AR тестыг хийсэн. (Зураг 2)



**Figure2 The VAR model's Stability Condition Check**

VAR (2)-д хийсэн co-integration test-ийн үр дүнг хүснэгт 3-т харуулав.

**Table 3 The VAR model's Johansen Cointegration Test Results**

Null hypothesis	eigenvalue	Trace statistic			Maximum characteristic root		
		statistics	5% critical value	P value	statistics	5% critical value	P value
Null	0.866205	66.78729*	47.85613	0.0003	36.20610*	27.58434	0.0031
$U_p$ to one	0.735608	30.58119*	29.79707	0.0405	23.94580*	21.13162	0.0195
$U_p$ to two	0.280907	6.635391	15.49471	0.6204	5.935753	14.26460	0.6215
$U_p$ to three	0.038123	0.699638	3.841466	0.4029	0.699638	3.841466	0.4029

Хүснэгт 3 туршилтын үр дүнгээр co-integration regression байхгүй гэсэн таамаглалаас татгалзаж байна. 5%-ийн ач холбогдлын түвшин (significance level of 5%)-д хувьсагчдын хооронд хоёр co-integration regression байна. Мөн LNIM, LNEX, LNTEI, LNFDI нь урт хугацааны тогтвортой хамааралтай

байна.

**Granger causality test:** 4 хувьсагчийн хооронд урт хугацааны тогтвортой хамаарал байгааг тодорхойлсны дараагаар Granger causality test-ээр хувьсагчдын хооронд causality хамаарал байгаа эсэхийг шалгах хэрэгтэй. Энэ нь causality хамаарлыг батлахын тулд X-ийн хоцрогдсон утгыг Y-ийн регрессийн тэгшитгэлд оруулах юм. Үр дүнг хүснэгт 4-т харуулав.


Table 4 The Granger causality test results of Variables

Dependent variable	Independent variable	Null hypothesis	F statistics	P value	result
LNIM	LNEX	LNEX does not cause LNIM	1.24565	0.3444	Not reject the null hypothesis
	LNTEI	LNTEI does not cause LNIM	1.05460	0.4109	Not reject the null hypothesis
	LNFDI	LNFDI does not cause LNIM	1.51922	0.2691	Not reject the null hypothesis
LNEX	LNIM	LNIM does not cause LNEX	1.41028	0.2966	Not reject the null hypothesis
	LNTEI	LNTEI does not cause LNEX	1.14096	0.3792	Not reject the null hypothesis
	LNFDI	LNFDI does not cause LNEX	0.59614	0.6318	Not reject the null hypothesis
LNTEI	LNIM	LNIM does not cause LNTEI	0.49574	0.6933	Not reject the null hypothesis
	LNEX	LNEX does not cause LNTEI	0.61628	0.6200	Not reject the null hypothesis
	LNFDI	LNFDI does not cause LNTEI	1.32338	0.3209	Not reject the null hypothesis

LNFDI	LNIM	LNIM does not cause LNFDI	3.14708	0.0735	Reject the null hypothesis
	LNEX	LNEX does not cause LNFDI	7.50822	0.0064	Reject the null hypothesis
	LNTEI	LNTEI does not cause LNFDI	3.17499	0.0721	Reject the null hypothesis

Дээрх хүснэгтэд 5%-ийн ач холбогдлын түвшин (significance level of 5%)-д импорт нь шууд хөрөнгө оруулалтын шалтгаан биш гэсэн анхдагч таамаглалаас татгалзаж байгаа учир импорт нь шууд хөрөнгө оруулалтын шалтгаан юм. Харин шууд хөрөнгө оруулалт нь импортын шалтгаан биш гэсэн анхдагч таамаглалаас татгалзахгүй байгаа учир шууд хөрөнгө оруулалт нь импортын шалтгаан биш юм. Иймд импортын хэмжээн нь шууд хөрөнгө оруулалттай нэг чиглэлээр үр дүнгийн хамааралтай. Үүний адилаар экспортын хэмжээ болон экспорт импортын нийт хэмжээ нь шууд хөрөнгө оруулалттай нэг чиглэлээр үр дүнгийн хамааралтай байна.

**Pulse response analysis:** VAR загварын үндсэн дээр pulse response figure-т тулгуурлан Монгол-Хятад хоёр улсын худалдаа, шууд хөрөнгө оруулалтын хамаарлын үр дүнд нарийвчилсан шинжилгээ хийв. pulse response функц нь нэг хувьсагчийн стандарт хазайлт бусад хувьсагчийн одоогийн болон ирээдүйн утгуудад нөлөөлөх байдлыг хэмжиж, хувьсагч бүрийн хоорондын харилцан динамик нөлөөлөл болон нөлөөллийн их, багыг ойлгомжтойгоор харуулдаг. Granger causality test-ийн үр дүн экспортын хэмжээ, импортын хэмжээ, экспорт импортын нийт хэмжээ нь шууд хөрөнгө оруулалтын шалтгаан гэж тодорхойлсон бол энд бид тэдний нэг эндоген хувьсагчийг загварт хэрхэн нөлөөлж байгааг авч үзнэ. pulse response analysis-ийн үр дүнг зураг 3-т харуулав.






Figure3 The pulse response of variables

Гурван хувьсагчийн pulse response figure-ээс импортын хэмжээний шууд хөрөнгө оруулалт дахь нөлөөлөл нь хоёр дахь үеэс эхлэн аажмаар нэмэгдэж, тавдугаар үед хамгийн өндөр түвшинд хүрээд цаашдаа аажмаар буурчээ. Экспортын хэмжээ болон экспорт импортын нийт хэмжээний шууд хөрөнгө оруулалт дахь нөлөөлөл нь импортын нөлөөлөлтэй бараг адил байна. Иймд pulse response analysis-ийн үр дүн Granger causality test-ийн үр дүн адил байгаа юм.

Нэг талаар экспортын хэмжээ, импортын хэмжээ, экспорт импортын нийт хэмжээ нь шууд хөрөнгө оруулалтын шалтгаан болдог. Үүнийг онолын үүднээс тайлбарлавал: (1) Үндэстэн дамнасан компани олон улсын зах зээлд үйл ажиллагаагаа явуулах явцдаа хүлээн авагч улстай худалдааны харилцааг бий болгож, цаашдаа энэхүү харилцаагаар дамжин хүлээн авагч улсын бодлого, хууль эрх зүйн орчинтой аажмаар танилцдаг. Хүлээн авагч орны зах зээлд тодорхой байр суурьтай, тэрчлэн нөлөө үзүүлэх хэмжээний хүчирхэг болсоны дараашууд хөрөнгө оруулалт хийх шийдвэрийг гаргадаг. (2) Хөрөнгө оруулагч улс болон хүлээн авагч улсын хоорондох худалдааны хамтын ажиллагаа нь харьцангуй боловсронгуй түвшинд байна. Экспорт, импортын өсөлтийг дагаад хүлээн авагч улс зарим шинээр бий болсон үйлдвэрлэл, нөөц баялагт суурилсан үйлдвэрлэлээ хамгаалахын тулд тарифын болон тарифын бус хязгаарлалтуудыг хэрэгжүүлж, анхдагч бүтээгдэхүүний хил дамнасан тээвэрлэлтэнд нөлөөлөхөөр эрмэлздэг. Энэ үед хөрөнгө оруулагч компани хүлээн авагч оронд шууд хөрөнгө оруулалт хийх замыг сонгоно.

Нөгөө талаар шууд хөрөнгө оруулалт нь экспортын хэмжээ, импортын хэмжээ, экспорт импортын нийт хэмжээний үчин зүйл болж чаддаггүй. Үүнийг тайлбарлавал: (1) Худалдаа, хөрөнгө оруулалтын харилцан нөхвөрлөх онолоор

үндэстэн дамнасан компани хүлээн авагч оронд үйлдвэрлэл-тээвэрлэлт-худалдаа гэсэн хэлбэрээр хөрөнгө оруулалт хийнэ. Ингэснээр хөрөнгө оруулагч улс хагас боловсруулсан болон бэлэн бүтээгдэхүүнийг хил дамжуулан тээвэрлэх нь буурна. Энэ нь магадгүй Монгол-Хятад хоёр улсын хоорондох шууд хөрөнгө оруулалт экспорт, импортын хэмжээнд түлхэц өгч чадахгүй байгаагийн нэг шалтгаан болох юм. (2) Ерөнхийдөө хоёр улсын хооронд худалдааны саад тогтор байгаа тохиолдолд л хөрөнгө оруулагч улсын хүлээн авагч оронд оруулж байгаа шууд хөрөнгө оруулалт нь бүтээгдэхүүний худалдаа арилжааг орлоно. Хятад улс нь Монгол улстай харьцуулахад хөгжлийн өндөр түвшинд хүрсэн. Мөн бүс нутгийн эдийн засгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг бий болгохын тулд Монгол улсад их хэмжээний тусламж үзүүлж ирсэн. Үүний ихэнх нь дэд бүтцийн салбар болон боомтуудын тээвэрлэлтийн хүчин чадалд чиглэгдсэн байна. Гэвч ийм их хэмжээний шууд хөрөнгө оруулалт нь хоёр улсын экспорт, импортод онцгой өөрчлөлт бий болгосонгүй.

### **Дүгнэлт**

Эмпирик болон онолын судалгаа нь Монгол-Хятад хоёр улсын хоорондох худалдаа, хөрөнгө оруулалтын явц нь харьцангуй бие даасан биш, хоорондоо тодорхой харилцан уялдаатай байгаа нь худалдаа, хөрөнгө оруулалтын интеграцчилалын онцлог болон чиг хандлагатодорхой түвшинд хүрсэнийг харуулж байна. Хэдийгээр Хятад улс Монголд улсад тусалцаа үзүүлэх зорилготой хөрөнгө оруулалтыг ихээхэн хийсэн ч худалдааг орлохоор хэмжээний нөлөөлөл харагдахгүй байна. Гэвч хүлээн авагч улс дахь зах зээлд чиглүүлэх хэлбэрийн хөрөнгө оруулалт нь худалдаа үйлчилгээний шинэ эрэлтийг бий болгохыг үгүйсгэхгүй. Монгол-Хятадын эдийн засаг, худалдааны харилцаа нь Хятадын хил залгаа орших орнуудтай холбогдсон гадаад эдийн засгийн харилцааны чухал хэсэг учраас хоёр талын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааг тогтвортой хөгжүүлэхийг чухалчилж ирсэн. Монгол улсын гадаад эдийн засгийн харилцааны хувьд Хятадтай хийх эдийн засаг, худалдааны харилцаа нь чухал байр суурь эзэлсээр ирсэн. Хоёр улс нь олон улсын тавцанд хамтын ажиллагааны давуу талтай, нөөц бололцоо ихтэй зэргээс дүгнэхэд цаашид Монгол-Хятад хоёр улсын эдийн засгийн хамтын ажиллагаа амжилттай явагдах талаархи хүлээлт их байна.

Монгол-Хятад хоёр улсын худалдаа, хөрөнгө оруулалтын салбарын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн хөгжүүлэхийн тулд юуны өмнө Хятад-АСЕАН-ийн эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаа, Хойд Америкийн улсуудын эдийн засгийн интеграцчилал зэрэг амжилттай хэрэгжиж байгаа загвараас туршлага,



санаа авч холбогдох арга зам, орчин нөхцөлийг бий болгох хэрэгтэй. Хятад улс нь АСЕАН-ы хөгжиж буй орнуудтай газар зүйн байршлын хувьд ойр, эдийн засгийн харилцан нөхвөрлөх чадамж өндөртэй юм. Хятад, АСЕАН-ийн хооронд дээд хэмжээний хэлэлцээрийн механизмыг бий болгож, худалдаа, хөрөнгө оруулалтын гэрээнд гарын үзэг зурсан явдал нь бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны тогтолцооны үндэс суурийг тавьж, харилцан ашигтай хамтын ажиллагааны загвар нь Хятад, АСЕАН-ийн худалдааны чөлөөт бүсийг амжилттай хөгжүүлж байна.

Түүнчлэн Хойд Америкийн худалдааны чөлөөт бүс нь дэлхийд анх удаа хөгжингүй орнуудын хамтран бий болгосон бүс нутгийн эдийн засгийн интеграцчилалын байгуулал юм. Гишүүн орнууд болох Америк, Канад, Мексик нь эх газрын хилийн урт зурвасаар холбогдсон төдийгүй, эдийн засаг, соёл, улс төр зэрэг олон талын тэнцвэргүй нөхцөл байдалд улс хоорондын эдийн засгийн хамтын ажиллагааг бий болгож эдийн засгийн интеграцчилалыг хэрэгжүүлсэн байна. Хамгийн том ололт нь худалдаа, хөрөнгө оруулалтын механизмаар дамжуулан аж үйлдвэр болон эдийн засгийн бүтцийг оновчтой болгож, хөдөлмөрийн нөөцөд оновчтой, үр ашигтай хуваарилалт хийснээр ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх гол зорилгодоо хүрсэн явдал юм.

Хэдийгээр Монгол-Хятад улсууд нь хөгжлийн хүрсэн түвшинээрээ Америк, Канад, Мексикээс ялгаатай боловч урт хугацаанд тарифын хязгаарлалтыг багасгах, татвараас чөлөөлөх, эдийн засаг, худалдааны бодлогыг сайжруулах, худалдааны чөлөөт бүсийг ашиглан үйлдвэрлэлийн харилцан нөхвөрлөсөн бүтцийг бий болгох, гаалийн бүрдүүлэлтийн үр ашгийг нэмэгдүүлэх зэрэг ололттой туршлага, арга хэмжээ нь хоёр улсын худалдаа, хөрөнгө оруулалтын интеграцчилалын хөгжилд онолын болон практик туршлага болох нь дамжиггүй. Монгол-Хятад хоёр улсын эдийн засгийн харилцаа чухам хэрхэн хөгжих нь хоёр орны улс төрийн харилцан итгэлцэл, олон нийтийн үзэл санааны үндэс сууриас шалтгаална. Хоёр улсын хоорондох худалдаа, хөрөнгө оруулалтын интеграцчилалын түвшинг ахиулах нь хоёр орны улс төр, нийгмийн сөрөг хүчин зүйлсийг арилгаж, эдийн засгийн хамтын ажиллагааг шинэлэг арга замаар хэрэгжүүлэх үндэс болох юм.

### Ашигласан материал

1. Bai Qing Sen/白庆森、Kang Xiao Guo/康晓国. Монгол-Хятадын худалдаа, хөрөнгө оруулалтын өнөөгийн байдал, ирээдүйн хүлээлт—БНХАУ-ын эдийн засгийн хөгжлийн горимыг өөрчлөх үндсэнд/中蒙两国贸易投资现状及未来展望——基于中国经济发展方式转型的视角[J]. Бизнесийн эдийн засаг/商业经济, 2011 (23) : 79-81
2. Batbileg Zayaajargal. Bilateral Relations between China and Mongolia[D]. Shan Dong University, 2014-4-11
3. Fang Fang/芳芳. Монгол дахь Хятадын шууд хөрөнгө оруулалтын өнөөгийн байдлын судалгаа/中国对蒙古国直接投资现状研究 [D] Хөххот: Өвөр Монголын их сургууль/呼和浩特: 内蒙古大学, 2010-6-1
4. Gao Ben Quan/高本权: Тэнцвэр—Монгол-Хятадын эдийн засгийн хамтын ажиллагааны бодлого, зорилго/均衡——中蒙经济合作关系中的策略与目标 [J], Өвөр Монголын санхүү эдийн засгийн их сургууль /内蒙古财经学院学报,2008(6):51-54
5. Gao Ben Quan/高本权: Зүүн хойд Азийн олон улсын тавцан дахь Монгол-Хятадын хамтын ажиллагааны харилцааны хэлэлцүүлэг》/试论东北亚国际背景下的中蒙合作关系[J], Өвөр Монголын санхүү эдийн засгийн их сургууль /内蒙古财经学院学报, 2009(6):39-42
6. Gao Ben Quan/高本权: Монгол-Хятадын хамтын ажиллагаан дахь эргэцүүлэл /中蒙合作关系研究中的几点思考[J],Өвөр Монголын санхүү эдийнзасгийн их сургууль /内蒙古财经学院学报,2010(6):50-52
7. Hu Jian/胡键. “Нэг бүс-Нэг зам” стратегийн бодлого, түүний хэрэгжилтийн судалгаа/“一带一路”战略构想及其实践研究 [M]. Бээжин. Цаг үе хэвлэлийн үйлдвэр /北京. 时事出版社, 2016: 1-1
8. Jiang Tao/姜涛. Монгол дахь Хятадын шууд хөрөнгө оруулалтын худалдааны үр нөлөөний судалгаа/中国对蒙古直接投资的贸易效应研究[D], Hebei муж: Anhui Их сургууль/合肥: 安徽大学, 2015 : 5-1
9. Jin Feng Hua/金凤花、 Yu Li Min/于丽敏. Heilongjiang мужийн гадаад дахь хөрөнгө оруулалтын өнөөгийн байдал, хөгжлийн бодлого-Монгол, Оросын жишээн дээр /黑龙江省对外投资现状与发展对策——以俄、蒙两国为例 [J]. /黑龙江对外经贸, 2011 (8) : 14-16
9. Li Hui/李慧. Монгол-Хятадын эдийн засаг худалдааны хамтын ажиллагааны өнөөгийн байдал болон бодлого/中蒙经贸合作现状

- 及对策[J]. Олон улсын эдийн засаг худалдаа/国际经贸, 2008(1) : 11-13
10. Li Jun Jiang/李俊江, Song Bo/宋博. Монгол-Хятад хоёр улсын эдийн засгийн хамтын ажиллагааны өнөөгийн байдал болон хөгжлийн төлөв/中蒙经贸合作的现状与发展前景 [J].Зүүн хойд Азийн форум /东北亚论坛, 2008 (3) : 25-28
  11. Li Xue Xin/李雪欣. Гадаад дахь Хятадын шууд хөрөнгө оруулалтын аж үйлдвэрийн сонголтын хэлэлцүүлэг/论中国对外直接投资的产业选择[J].Shenyang Их сургууль ЭШ-ний сэтгүүл /沈阳大学学报, 2000 (1) : 27-30
  12. Lin Yan/林燕.Өвөр Монголын ААН-үүдийн Монгол, Орос дахь хөрөнгө оруулалтын асуудлын судалгаа/内蒙古企业对俄蒙投资问题研究 [J]. Өвөр Монголын санхүүгийн судалгаа/内蒙古金融研究,2015(3):33-34
  13. Na Lin/娜琳. Монгол улсын “Олон талт” гадаад хамтын ажиллагааны бодлого, их гүрнүүд дэхь харилцаа /蒙古国“多支点”外交战略与大国关系[J]. /2004(1) :82-87
  14. Pu Yang Chun/朴养春.Монгол-Хятадын худалдааны хамтын ажиллагааны хэтийн төлөвлөлт/中蒙贸易关系的展望 [J].Yanbian Их сургуулийн ЭШ-ий сэтгүүл/延边大学学报, 1997(4): 1-4
  15. Shang Pei Feng/尚佩峰、Zhang Jun/张军. Мандуул боомтын гаднах хил дамнасан хөрөнгө оруулалт, санхүүгийн үйлчилгээний нөхцөл байдлын судалгаа/对满都拉口岸境外跨境投资和金融服务情况的调查 [J]. Санхүүгийн нягтлан бодох бүрдгэл/金融会计, 2009 (6) : 19-20
  16. Shao Bing/邵冰. Монгол-Хятадын эдийн засаг, хамтын ажиллагааны өнөөгийн байдал, бодлого/中蒙经贸合作的现状及对策[J]. /经济视角, 2011(8):168-169
  17. Tang Hui Liang/唐辉亮. Монгол-Хятадын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны хөгжил, түүнд оршиж буй асуудал/中蒙经贸关系的发展与存在的问题[J]. Бизнес Таймс/商业时代, 2006(34) : 36-37
  18. Yao Hai Hua/姚海华. Монгол-Хятад хоёр талын худалдааны бүтцийн шинэчлэлийн шинжилгээ/中国与蒙古国双边贸易结构演进分析 [J].Өвөр монголын нийгмийн шинжлэх ухааны сэтгүүл /内蒙古社会科学 (汉文版), 2009 (6) : 1-6
  19. Zhang XiuJie /张秀杰. Зүүн хойд Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаан дахь Монгол, Орос, Хятадын эдийн засгийн коридорын судалгаа/东北亚区域经济合作下的中蒙俄经济走

- 廊建设研究[J]. Эдийн засгийн өсөлт, хөгжил/经济增长与经济发展, 2015(6): 6-10
20. Zhang XiuJie/张秀杰. Зүүн хойд Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаан дахь Монгол, Орос, Хятадын эдийн засгийн корридорын судалгаа/东北亚区域经济合作下的中蒙俄经济走廊建设研究[J]. Сурах, эрэлхийлэх/学习与探索, 2015(10): 105-108
  21. Zhang Ye Fang/张野芳. Монгол-Хятадын харилцааны хөгжлийн хязгаарлагч хүчин зүйлс/中蒙关系发展中的阻碍因素[D]. Jilin муж: Jilin-ий Их сургууль/吉林: 吉林大学, 2009:4-1
  22. Бүрэнжаргал/布仁吉日嘎拉. Юаны ханшны өсөлт Монгол улсын эдийн засагт нөлөөлөх нөлөөллийн судалгаа/人民币升值对蒙古国经济发展的影响研究[J]. Өвөр Монголын санхүү эдийн засгийн сургуулийн ЭШ-ий сэтгүүл/内蒙古财经学院学报, 2007(4):20-25
  23. Олон улсын шууд болон шууд бус хөрөнгө оруулалтын нягтралын шинжилгээ/浅析国际直接投资和间接投资的融合, 会计城, <http://www.kjcity.com/news>, 2015-11-10
  24. Оронч/敖仁其. Монгол болон Өвөр Монголын эдийн засгийн хамтын ажиллагааны өнөөгийн байдал, хэтийн төлөв/内蒙古与蒙古国经贸合作现状与前景[J]. Зүүн хойд Азийн форум/东北亚论坛, 2000 (10) : 35-38
  25. Т.Намжим : <Монголын эдийн засаг >. УБ, 2000 он.  
Үрцэцэг/乌日其其格: 《 Монгол улсын эдийн засгийн шилжилтийн явц хийгээд түүний үр дагавар》 / 《蒙古国经济转轨重大举措及其社会经济的影响》, Хөх хот/呼和浩特, Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хороо/内蒙古人民出版社, 2006 он/2006年.
  26. Чэн Сиү Шан/陈秀山, Жан Ке Юн/张可云: 《 Бүс нутгийн эдийн засгийн онол 》 / 《区域经济理论》. Бээжин/北京, Шань Ү хэвлэлийн газар/商务印书馆, 2005 он/2005年.
  27. Энхээ/恩和. Зүүн хойд Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа, Өвөр Монголын эдийн засгийн хөгжил: Одоогийн байдал болон хэтийн төлөв/东北亚区域经济合作与内蒙古经济发展:现状与前景[J]. Зүүн хойд Азийн форум/东北亚论坛, 1998 (4) : 51-55
  28. Энхээ/恩和. Зууны эргэлтэнд байгаа Монгол-Хятадын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаа: Одоо болон ирээдүйд/世纪之交的中蒙经贸关系:现状与展望[J]. Өвөр Монголын их сургуулийн ЭШ-ий сэтгүүл/内蒙古大学学报, 1999 (6) : 39-46